

БАТЛАВ.  
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД ЧОЙБАЛСАН ХОТЫН  
ЗАХИРАГЧ О ПҮРЭВ-ОЧИР

**ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН ХОТЫН “ХҮҮХДИЙН ПАРК” -ЫН ЕРӨНХИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЖЛЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР**

2023.12.14

Дугаар...

Чойбалсан хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.5, 6.2.17. дахь заалтуудыг үндэслэн.
2.	Байршил эдэлбэр, газрын хэмжээ	<ul style="list-style-type: none"> <li>Дорнод аймаг Хэрлэн сум 3-р баг, Хотгор дэрст</li> <li>Нийт хийгдэх талбай 22 га</li> <li>Ногоон байгууламж, явган хүний зам, авто зам, зогсоолын тохижилт 8.8 га</li> <li>Нуур цөөрөм 1,2 га</li> <li>Тоглоом, тоног төхөөрөмж, тоглоомын төв, оффис болон аж ахуйн зориулалттай барилгажсан талбай 12 га</li> </ul>
3.	Зориулалт, хүчин чадал	Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн жилийн 4 улиралд үйлчлэх 4000 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай.
4.	Одоогийн байдал	Уулын хөнгөн шавранцар хүрэн хөрстэй, бетон цутгасан 7500м <sup>2</sup> талбайтай.
5.	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаарлага	<ul style="list-style-type: none"> <li>Эдэлбэр газарт инженер геологийн дүгнэлт гаргуулах, газар дээрх болон доорх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төсвийг боловсруулах.</li> <li>Гадаргуугийн ус зайлцуулах арга хэмжээг орчны байгууламжуудтай нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.</li> <li>Цахилгаан эрчим хүч, холбоо техник хангагч байгууллагаас техникийн нөхцлийн дагуу төвийн нэгдсэн сүлжээгээр хангах.</li> <li>Дулаан, цэвэр бохир ус зайлцуулах шугам сүлжээг бие даасан байдлаар шийдэх.</li> </ul>
6.	Төлөвлөлтийн орон зайд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>Архитектор болон орон зайн төлөвлөлтийг бүсийн онцлог, шаардлага, холбогдох хууль, норм ба дүрмийг мөрдлөгө болгох.</li> <li>“Хүүхдийн парк”-ийг насын ангилалаар сэдэвчилсэн, зохиомжтой байдлаар шийдэж, орчин үеийн шинэлэг өнгө үзэмж сайтай сайн чанарын</li> </ul>

		<p>тоглоом, техник хэрэгсэл, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, авто зогсоол, дугуйн зам, явган зорчигчийн тусгай зам, насны ангилаал орчинд нь тохирсон түргэн хоолны газар, үйлчилгээний мини салбарууд, иргэдийн амарч зугаалах талбайг цогцоор нь шийдэх.</p> <ul style="list-style-type: none"> <li>· Оффис</li> <li>· Үйлчилгээний газар</li> <li>· Ресторан</li> <li>· Хөлбөмбөг, сагсан бөмбөгийн талбай</li> <li>· Хосуудын төгөл</li> <li>· Амьтны хүрээлэн</li> <li>· Хөгжимиин эгшигээр цацрах усан оргилуур</li> <li>· Автомат тоглоомын төв(боулинг) орчин үеийн дэвшилтэт технологи дээр суурилсан видео тоглоомийн төв</li> </ul>
		<p><b>Аттракцион тоглоом</b></p> <ul style="list-style-type: none"> <li>· Алсыг харагч</li> <li>· Гинжит тойруулга</li> <li>· Уран жолоодлогын машинууд</li> <li>· Галзуу хулгана</li> <li>· Хөгжөөнт аялалын галт тэрэг</li> <li>· Динозавр парк</li> <li>· Талбайн шатар</li> <li>· Co kart буюу галзуу хурд</li> <li>· Жижиг нуур цөөрөм түүнд хөвөх завиуд зэрэг тоглоомууд байна.</li> </ul> <p><b>Бага насны хүүхдийн тоглоомууд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>· Морин тойруулга /тоглоом/</li> <li>· Галт тэрэг</li> <li>· Алсыг харагч</li> <li>· Хөгжилтэй байвгай</li> <li>· Буутай машин гэх мэт.</li> </ul> <p><b>Явган зам талбай</b></p> <ul style="list-style-type: none"> <li>· Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж төлөвлөх.</li> <li>· Явган хүн хөгжлийн бэрхжээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх MNS6056:2009 стандарт, "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан" /БНБД 31-101-04/ "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлага хангасан зураг төсөл зохиох заавар" /БНБД 31-112-11/-ийн шаардлага хангасан замын өргөн орон зайдай төлөвлөх.</li> </ul>

	<p><b>Авто зогсоол</b></p> <ul style="list-style-type: none"> <li>“БНБД 30.01.04”-ийн 14 дүгээр хавсралт “Тээврийн хэрэгсэлийн зогсоолын норматив”, 18 дугаар хавсралт “Хот, тосгонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан төлөвлөлтийн шаардлагууд”-ыг баримтлах.</li> <li>300 машины авто зогсоол төлөвлөх.</li> </ul> <p><b>Ногоон байгууламж</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Ногоон байгууламжийг “БНБД 81.37.06” дагуу төлөвлөх.</li> <li>Шилмүүст болон навчit бут, сөөг, цэцгийн мандал, зүлэг тарьж орчны онцлогоор хэлбэр дүrs үүсгэж тохижилтыг зохиомжлох.</li> <li>Инженерийн шугам сүлжээ таараагүй хэсэгт мод тарих.</li> </ul> <p><b>Гэрэлтүүлэг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Гэрэлтүүлэг нь “БНБД 23.02.08” шаардлага хангасан, орчны тохижилтонд нийцсэн сайн чанарын загвар дизайн сайтай төлөвлөх.</li> <li>Гэрэлтүүлгийг авто зам, явган хүний зам, талбайн тохижилтын гэж ангилан архитектор орон зайн төлөвлөлттэй уялдуулсан шийдэлтэй байна.</li> </ul> <p><b>Хиймэл нуур</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Усан сан буюу хиймэл нуур цөөрмийг тоосжилтыг багасгах зорилгоор салхин талд төлөвлөх.</li> </ul> <p><b>Бусад</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Тохижилтыг орчны архитектор орон зайн төлөвлөлттэй уялдуулан хогийн сав (ангилан ялгах) сандал, саравч гэх мэт архитектурын жижиг хэлбэрүүдийг төлөвлөх.</li> </ul>	
7.	Зураг төсөл боловсруулах байгууллага	
8.	Ерөнхий төлөвлөгөө боловсруулах хугацаа	2023 оны 12-р сарын 14-нөөс 2024 оны -р сарын -ны өдөр хүртэлх хугацаанд боловсруулах;

Боловсруулсан:

ЧОЙБАЛСАН ХОТЫН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР  Л.ЭНХЗАЯА